

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Орхон аймаг

<p>НЭГ. Товч танилцуулга</p> <p>Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/17 дугаартай захирамжаар байгууллагын бүтэц орон тоо өөрчлөгдөн Газрын дарга-Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч-1, Ахлах мэргэжилтэн-Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч-1, Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч-2, Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч-4, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн-1, Нягтлан бодогч-1, Архив, бичиг хэргийн эрхлэгч-1, Нярав-1 гэсэн орон тоотойгоор ажиллаж байна.</p> <p>Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь Монгол Улсын Засгийн газрын 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн хүрээнд Орон нутгийн төсөвт байгууллага, Төрийн болон Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, хараат бус, бодитой дүгнэлт өгч, төсөв санхүүгийн үйл ажиллагааг сайжруулан, мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, засаглалын эрсдэлийг бууруулан ажилладаг.</p> <p>Бид 2019 оноос төрийн албаны ёс зүй үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, стандартад нийцсэн төрийн үйлчилгээг түргэн шуурхай чанартай хүргэх зорилгоор Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандарт, 2022 оноос Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 Олон улсын стандарт, 2025 оноос Эрсдэлийн менежментийн тогтолцооны ISO 31000:2018 Олон улсын стандартыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлж, харилцагчдыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сэтгэл ханамжийн түвшинг тасралтгүй дээшлүүлж, эрсдэлд суурилсан хяналтыг бий болгох, стандартад нийцсэн аудитын тогтолцоог төлөвшүүлэхэд салбарын түвшинд болон төрийн захиргааны байгууллагуудаа манлайлан ажиллаж байна.</p> <p>Байгууллагын Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлдээ нийцсэн Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого, зорилт, гарын авлагаа боловсруулан, байгууллагын стандартыг батлуулж, үйл ажиллагаандаа байнгын сайжруулалтыг хийж ажилладаг.</p>
<p>ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар</p> <p>2.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:</p>
<p>Байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-тэй холбоотой дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">➢ Байгууллагын 11 албан хаагчийн төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг ажлын байр, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг бүрээр авч, Монгол Улсын Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу эрсдэлийн үнэллээ. Ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг хийхэд байгууллагын албан хаагчдаас 3 албан хаагч бага эрсдэлтэй, 8 албан хаагч дунд эрсдэлтэй үнэлэгдлээ. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх өндөр


эрсдэлтэй болон маш өндөр эрсдэлтэй үнэлэгдсэн албан хаагч /албан тушаалтан/ гараагүй болно.

- Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор дээд шатны байгууллагуудаас зохион байгуулсан 3 удаагийн сургалтад хамрагдсан. Үүнд:

- “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт сургалтад байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-ны гишүүд хамрагдсан.
- 2025.02.20-ны өдөр “Төрийн албаны зөвлөл” Орхон аймагт ажиллах үеэр зохион байгуулсан сургалтад Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн танхимаар, бусад албан хаагчид цахимаар сургалтад хамрагдлаа.
- “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” хойд бүсийн зөвлөгөөнд Ёс дэд хорооны 1 гишүүн оролцлоо.



- Байгууллага дотооддоо “Соёлын хөтөлбөр”-ийг 2 дахь жилдээ хэрэгжүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Байгууллагын Ёс зүйн дэд хорооны 3 гишүүнийг “Удирдлагын академи”-ийн төрийн албан хаагчдад зориулсан “Ёс зүй” анхан шатны мэргэшүүлэх сертификаттай сургалтад хамруулсан.
- Байгууллагын цахим сайтад төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигаас ангид байх зэрэг нөлөөлөх контентыг бүтээж, олон нийтэд түгээн ажилласан. <https://www.youtube.com/watch?v=wJp7NwEqEvw>, <https://www.youtube.com/watch?v=Yz8hQbiBIUk>
- Байгууллагын <https://sankhuu.orkhon.gov.mn/> сайтад “Сэтгэл ханамжийн судалгаа”-г тогтмол байршуулан, улирал бүр үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж ажилладаг.



2.2. Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Нэгдсэн менежментийн тогтолцоог 3 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд: Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 олон улсын стандарт, Авлигын эсрэг менежментийн ISO 37001:2016 олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн салбартаа болон төрийн захиргааны байгууллагуудаа манлайлан ажиллаж байна. Энэ онд Эрсдэлийн менежментийн тогтолцооны ISO 31000:2018 Олон улсын стандартын баталгаажуулах аудитад амжилттай хамрагдснаар 3 стандарт хэрэгжүүлэгч байгууллага болсон. Байгууллагын дарга нь мэргэжлийн түвшинд хариуцлагатай, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажилладаг.

Байгууллагын дарга болон ахлах мэргэжилтэн 2025 онд 7 удаагийн сургалт, зөвлөгөөнд 9 дүүрэг, 21 аймгийн 186 албан хаагчдад Нэгдсэн менежментийн тогтолцоо хэрэгжүүлсэн сайн туршлагаа хуваалцан ажиллалаа.

ТЭРГҮҮН ТУРШЛАГА, МАНЛАЙЛАЛ - 2025

Төрийн албаны зөвлөгөөс Бүтээмж, Хөгжил "Төрийн албаны зөвлөгөөн-2025" манлайлал

Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын хамт олонд

19 аймгийн СКДАГ-ын удирдлага, ахлах мэргэжилтнүүд

Нийслэл, 17 аймгийн нутгийн захиргааны байгууллага

2025 ОНЫ IV УЛИРЛЫН БАЙДЛААР: ГАДАГШ ЧИГЛЭСЭН 7 УДААГИЙН СУРГАЛТААР 186 ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД САЙН ТУРШЛАГАА ХУВААЛЦСАН

Орхон аймгийн Гаалийн газар

"БҮТЭЭМЖ БА ИННОВАЦ" ХӨТӨЛӨӨ

Баянхонгор, Хөвсгөл аймгийн СКДАГ-ын хамт олонд

Орхон аймгийн Мал эмнэлгийн газар

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Л.БУЛГАНЦЭЦЭГ ОРХОН АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДААС ШАЛГАРАН САЙН ТУРШЛАГАА ХУВААЛЦСАН

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Байгууллагын даргын 2024 оны А/30 дугаартай тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган боловсруулж, байгууллагын даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар 100% ханган ажилласан. Үүнд:

- Шинээр томилогдсон 2 албан хаагчид “Төрийн албаны ёс зүйн тухай хууль”, Ёс зүйн дүрэм, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн.

1.Зорилго
Төрийн албаны ёс зүйн тухай хууль, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн.

2.Хангах хүрээ
Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын хамт олонд

3.Далбаа хариуцаж үйл ажиллагаанд бэрхшээлээ зарцуулж
Ажлын явцаа нь: 2025 оны 1-р сард төрийн албаны ёс зүйн тухай хууль, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн.

4.Танилцуулгын харьцаанд танилцуулсан
4.1 Албан хаагчид төрийн албаны ёс зүйн тухай хууль, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн.
4.2 Албан хаагчид төрийн албаны ёс зүйн тухай хууль, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн.
4.3 Албан хаагчид төрийн албаны ёс зүйн тухай хууль, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн.
4.4 Албан хаагчид төрийн албаны ёс зүйн тухай хууль, журмыг танилцуулж, цаашид төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг мөрдөх, сахилга хариуцлагаа дээшлүүлж ажиллах талаар зөвлөгөө өгсөн.



- 2025 онд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнтэй холбоотой иргэн, хуулийн этгээдээс гомдол ирээгүй болно.
- Ёс зүйн дэд хороо Албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага,

соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг байгууллагын Ёс зүйн дэд хороо “Насан туршийн суралцахуйн төв”, Эрүүл мэндийн газар”, “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар” зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. 8 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 83 албан хаагч хамрагдсан.



- “Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба” фэйсбүүк пэйж хуудас болон албан хаагчдын дундын групп-т Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Байгууллагын стандарт, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор **35 удаагийн** байршуулж ажилласан.
- Сар бүр албан хаагчдыг идэвхжүүлэх 1 арга хэмжээг “Удирдамж”-аар батлуулан хэрэгжүүлэлтийг хангаж ажилласан.

2025 онд 4 удаа буюу улирал бүр төлөвлөгөөний биелэлтийн тайланг “Төрийн албаны Орхон аймаг дахь салбар зөвлөл”-д хүргүүлж ажиллалаа.

“Соёлын хөтөлбөр”-ийг байгууллагадаа 2 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хөтөлбөрийн төлөвлөгөө тайланг ёс зүйн дэд хороо хариуцан ажилладаг. 2025 онд Соёлын хөтөлбөрийн хүрээнд 3 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

- Стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулсан “Байгууллагын стандарт”-ыг бүх албан хаагчдад хэвшүүлэх зорилгоор баримтлах зарчим, тавигдах шаардлага тус бүрийг дотоод группээр 10 удаа мэдээ, мэдээллийг хүргэсэн.
- Байгууллагын албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 12 сар тус бүрд нэр өгч, сар бүр нэршилтэй холбоотой арга хэмжээ
- “Ажлын байран дахь албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа”-г бүх албан хаагчдаас 2025 оны 06 дугаар сард авч, нэгтгэн судалгааны үр дүнг байгууллагын даргад танилцуулж ажилласан. Энэхүү судалгаа нь албан хаагчдын ажлын орчин, удирдлага, хамт олон, цалин урамшуулал болон хөгжлийн боломжийн талаарх сэтгэл ханамжийг үнэлэх зорилготой авсан.

Пүрэжав Даваажаргал

Өдрийн мэнд. “Ажлын байран дахь албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа”-д бүх албан хаагчид 2025.06.25-ны өдрийн 18 цагаас өмнө хамрагдана уу. Энэхүү судалгаа нь байгууллагын ажлын орчин, удирдлага, хамт олон, цалин урамшуулал болон хөгжлийн боломжийн талаарх таны сэтгэл ханамжийг үнэлэх зорилготой. Судалгааны хариулт нь нууцлалтай хадгалагдаж, зөвхөн дотоод сайжруулалтад ашиглагдана. Судалгаанд хамрагдсанаа комент хэсэгт үлдээж үү. Баарлалаа.

https://docs.google.com/_/1FAIpQLSf800.../viewform...

Ажлын байран дахь албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа

Өмнө судалгааг хариуцахыг хүсьеэн үгүйсгэхгүйгээр үндэслэлтэй хариу өгнө.

АЖЛЫН БАЙРАН ДАХЬ АЛБАН ХААГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАНЫ ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр

Орхон аймаг

Судалгааны зорилго: Байгууллагын соёл, ажлын орчин, хамт олон хоорондын харилцаа, хөгжлийн, уур амьсгал, цалин урамшуулал үйл ажиллагаанд сэтгэл ханамж хэр байгаа талаар үндэслэлтэй, үнэлэлт дүгнэлт хийж, илэрсэн алдаа дутагдлыг арилгах, цаашд сайжруулах зорилготой.

2025 оны 06 дугаар сард “Ажлын байран дахь албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа”-г байгууллагын дундын группэд нээлттэй байршуулж судалгаанд 8 албан хаагч оролцсон байна.

Уг судалгаа нь нийт 12 асуумжтай бөгөөд албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамж ямар байгаа, байгууллагаас үзүүлж болж аргаарцаа хүлээлтийг тодорхойлох, албан хаагчдын хоорондын харилцаа хандлага зэрэг үзүүлэлтүүд үнэлэгдэнэ. Судалгаанд хамрагдсан албан хаагчид дараах үнэлгээг өгсөн байна.



- 2025.05.14-ний өдөр "Ворлд стандарт кансолтинг" ХХК-ийн хамтын ажиллагааны хүрээнд нийт албан хаагчдад тус байгууллагын ISO 9001 стандартын Тэргүүлэх аудитор, Менежментийн зөвлөх, лектор А.Батгэрэл багштай хамтран "Coaching and feedback" сэдэвт өглөөний сургалтыг зохион байгуулж, албан хаагчдынхаа шинэ мэдлэг ойлголтыг өгч, идэвхжүүлж ажиллалаа.

- Хамт олны дунд ёс зүй, харилцаа хандлагын талаар нөлөөллийн томоохон ажлын нэг болох байгууллагын бүх албан хаагчдын дунд “Илтгэл”-ийн уралдаан зохион байгуулсан.



- “Хайр, халамжаа хуваалцаж сэтгэлийн өглөг түгээе уриатай” хүүхдүүдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, сэдэвчилсэн тоглоомуудыг Эрдэнэ багийн 11-р цэцэрлэгийн гурван бүлгийн хүүхдүүдэд гардуулан өгсөн.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
<p>Албан хаагчдыг сар бүр тогтмол идэвхжүүлж, сургалтад хамруулснаар дараах ололт амжилт бий болсон. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын соёл, хамтын ажиллагаа сайжирсан. ➤ Албан хаагчдын Ёс зүй, хариуцлага дээшилсэн. ➤ Албан хаагчдын сэтгэл ханамж, тогтвортой байдал нэмэгдсэн. 	<p>Ажлын тайланг олон хэлбэрээр хийж, мөн олон газарт хүргүүлдэг нь хүндрэлтэй байдаг.</p>
Санал: Байхгүй.	

Шалгах хэсэг:

- “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх
- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх
- Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР